



**ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/38

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 27.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Баруун хошууны Алтан-Эмээл, Манжуур хотын Ардын засгийн ордны үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга:

Н.Хүрэлээ

Цэргийн штабын дарга, дэд хурандаа

Гишүүд:

Ж.Ганбаяр

Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Ц.Ганчимэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга


Л.Цэнддорж

Цэргийн штабын офицер

2. Туршлага судлах, үйл ажиллагаатай танилцах хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

3. Уг арга хэмжээг зохион байгуулалтын өндөр хэмжээнд зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Н.Хүрэлээ/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР